

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛД ГАРСАН
ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2023.07.24

Алтай хот

Хяналт-шинжилгээний зорилго: Аймгийн Засаг даргын 2023 оны хагас жилд гарсан захирамжийн хэрэгжилтийг тодорхойлох, явцын хяналт-шинжилгээ хийж, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудыг бодит мэдээллээр хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдлээ.

Хяналт-шинжилгээний арга зүй: Хяналт-шинжилгээг аймгийн Засаг даргын 2022 оны А/170 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгож, Хууль, эрх зүйн хэлтсээс нэгтгэн ирүүлсэн хэрэгжилтэд үндэслэн гүйцэтгэлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн: 2023 оны хагас жилийн байдлаар нийт 361 захирамж гарсан бөгөөд хяналтад байгаа 289 захирамжийн хэрэгжилтийн товчоог танилцуулбал:

Хяналтад авсан захирамжийн тоо	289
Бүрэн хэрэгжсэн /100 %/	211
Хэрэгжих шатанд /70 %/	60
Хэрэгжилт хангалтгүй /30 %/	15
Хэрэгжээгүй /0 %/	2
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	1
БИЕЛЭЛТИЙН ДҮН /ХУВЬ/	89.4

“Хэрэгжээгүй” буюу “0” хувьтай 2 захирамжийн, шалтгаан:

№	Огноо, дугаар, товч утга	Захирамжийн агуулга	Шалтгаан, тайлбар
1	A/195 2023.04.11 Хувийн хэвшил, Төрийн бус байгууллагаар ажил гүйцэтгүүлэх тухай	1.Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, орон нутагт хэрэгжиж буй төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн үйл явцыг иргэд, олон нийтэд сурталчилах, мэдээ мэдээллийг түгээх ажлыг “Их Алтайн Цадиг” ХХК-иар гүйцэтгүүлсүгэй.	Их Алтайн цадиг ХХК-ийн Алтайн мэдээ агентлагаас тайлан ирүүлээгүй.
2	A/211 2023.04.19 Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай	1.Жаргалан сумын нутаг Хужирт нэртэй газрын 274.52 га талбайд Ашигт малтмал газрын тосны газраас давхцалгүй гэсэн дүгнэлт ирүүлсэн тул “Хабун мандал” ХХК-д түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгосугай. 4.Хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг тусгай зөвшөөрлийн болон зураг зүйн	Ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа эхлээгүй байна.

		бүртгэлд бүртгэж, хуулийн дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (С.Амгалан), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Болдбаатар), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас), Жаргалан сумын Засаг дарга (П.Авиurmэд)-д тус тус даалгасугай.	
--	--	--	--

ДҮГНЭЛТ

Аймгийн Засаг даргын 2023 оны хагас жилийн байдлаар гарсан захирамжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Аймгийн Засаг даргын 2023 оны хагас жилийн байдлаар гарсан 361 захирамжаас хяналтад байгаа 289 захирамжийн 211 нь 100 %, 60 нь 70 %, 15 нь 30 %, 2 нь 0 %, 1 нь хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй үнэлэгдэж, хэрэгжилтийн дундаж 89.4 хувьтай байна.

2.Хяналтад байгаа 289 захирамжийн 73.0 хувь нь бүрэн хэрэгжсэн, 20.7 хувь нь хэрэгжих шатанд байна. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа удаашралтай, удирдлага зохион байгуулалт дутагдалтайгаас 2 захирамжийн хэрэгжилт хангалтгүй байна.

3.Хэлтсүүд хяналтад авсан холбогдох заалтын хүрээнд үр дүнг тайлagnaагүй, зарим захирамжийн хэрэгжилтийн хувийг бодитой бус тооцсон байна.

4.Захирамжийн нэгтгэл үг үсгийн алдаатай, бичвэрийн тоо баримт зөрсөн зэрэг зөрчил дутагдалтай байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг даргын 2023 оны хагас жилийн байдлаар гарсан захирамжийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Нэг. Хууль, эрх зүйн хэлтэст:

1."Хэрэгжилт хангалтгүй" үнэлэгдсэн A/42 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулах, эрчимжүүлэх арга хэмжээ авах;

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх хугацааг мөрдөж ажиллах;

3.Захирамжийн заалтыг картлахдаа үг, үсгийн болон тоо баримтын алдаагүй бичих, хэрэгжилтийг нэгтгэхдээ холбогдох заалт тус бүрийн үр дүнг тайлагнасан эсэхэд хяналт тавих;

Хоёр. Нийгмийн бодлогын хэлтэст:

1."Хэрэгжилт хангалтгүй" үнэлэгдсэн A/218, A/219, A/264, A/338 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулах, эрчимжүүлэх арга хэмжээ авах;

2. Эрхлэх асуудлын хүрээнд хэлтэст болон харьяа агентлагт хамаарах захирамжийн хэрэгжилтийг тухай бүр хангуулах, “хэрэгжилт хангалтгүй”, захирамжийг хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах;

Гурав. Төрийн захиргааны удирдлагын хэлтэст:

1. “Хэрэгжилт хангалтгүй” үнэлэгдсэн A/45, “хэрэгжээгүй” A/195 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулах, эрчимжүүлэх арга хэмжээ авах;

Дөрөв. Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст:

1. Эрхлэх асуудлын хүрээнд хэлтэст болон харьяа агентлагт хамаарах захирамжийн хэрэгжилтийг тухай бүр хангуулах, “хэрэгжилт хангалтгүй”, “хэрэгжээгүй” захирамжийг хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах;

2. “Хэрэгжилт хангалтгүй” үнэлэгдсэн A/168, A/172, A/209, A/257, A/267, A/301, A/327, A/330, A/338, A/344, “хэрэгжээгүй” үнэлэгдсэн A/211 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангуулах, эрчимжүүлэх арга хэмжээ авах;

Тав. Орон нутгийн өмчийн газарт:

1. “Хэрэгжилт хангалтгүй” үнэлэгдсэн A/168, A/209, A/327 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулах, эрчимжүүлэх арга хэмжээ авах;

Зургаа. Эрүүл мэндийн газарт:

1. “Хэрэгжилт хангалтгүй” үнэлэгдсэн A/218, A/219 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх арга хэмжээ авах;

Долоо. Хүнс, хөдөө аж ахуйн газарт:

1. “Хэрэгжилт хангалтгүй” үнэлэгдсэн A/257 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх арга хэмжээ авах;

Найм. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт:

1. “Хэрэгжилт хангалтгүй” үнэлэгдсэн A/267, A/301, A/330 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулах, эрчимжүүлэх арга хэмжээ авах;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

